



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 03 сарын 25 өдөр

Дугаар А/220.

Арвайхээр сум

Орон нутгийн зөвлөл байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн "Иргэний эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэхэд чиглэсэн зарим арга хэмжээний тухай" 821 дүгээр тогтоол, "Эрүүл шүд" арга хэмжээг хэрэгжүүлэх тухай 322 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх, эрүүл мэндийг дэмжих орон нутгийн зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай. Үүнд:

Зөвлөлийн дарга: О. Сумъяасүрэн (аймгийн Засаг даргын Орлогч)

Гишүүд: Б.Сайнжаргал (аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлстийн дарга)

Г. Пүрэвдорж (аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Боловсрол, шинжлэх ухааны газрын дарга)

Т.Нарангарав (аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын дарга)

Ө.Жамдүдсансүм (аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Биеийн тамир, спортын газрын дарга)

Д. Шивааннүрдэв (аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Эрүүл мэндийн газрын дарга)

Б.Норовсүрэн (аймгийн Насан туршийн суралцахуйн төвийн дарга)

Нарийн бичгийн дарга: Б.Оюунчимэг (аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Эрүүл мэндийн газрын мэргэжилтэн)

Нарийн бичгийн дарга: Б.Гомбосүрэн (аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Боловсрол, шинжлэх ухааны газрын мэргэжилтэн)

2.Иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх, эрүүл шүд арга хэмжээг хэрэгжүүлэх, эрүүл мэндийг дэмжигч байгууллага хамт олныг шалгаруулах үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд салбар дундын зохицуулалт, удирдлага зохион байгуулалтаар ханган, дээрх арга хэмжээнүүдийг орон нутагт хэрэгжүүлэх төлөвлөгөөг боловсруулан батлаж, хяналт тавьж ажиллахыг Зөвлөлийн дарга (О.Сумъяасүрэн)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



И. ДОРЖСҮРЭН

6224 11 0458